



Уте Кумпф

Германы Бундестагийн гишүүн
“Иргэний идэвх зүтгэл” дэд хорооны орлогч дарга

Германы Бундестаг
11011 Берлин
☎ 030 - 227 – 73 729
📠 030 - 227 – 76 144
✉ ute.kumpf@bundestag.de

Вилхелмсплатц 10
70182 Штуттгарт
☎ 0711 - 23 31 40
📠 0711 - 23 50 99
✉ ute.kumpf@wk.bundestag.de

www.ute-kumpf.de

Уте Кумпф, МдБ (Бундестагийн гишүүн – орч.)

2010.07.30-ны байдлаар

ГСДН*-ын ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл

Нийгмийн ардчилал

- Эрх чөлөө бол ГСДН-ын уг үндсэн сэдэв нь юм. Хүн бүрийн эрх чөлөө зөвхөн ардчиллын үед хөгжин дэгжиж чадна. Ардчилал нь эрх чөлөөний амьд биелэл мөн. Тиймээс ГСДН-ын 150 жилийн түүхийн туршид эхлээд эрх чөлөөг бий болгох, дараа нь түүнийг хамгаалах, эцэст нь шинэчлэх явдал түүний гол зорилго нь байлаа. Энэ шаардлагуудыг залгуулан ГСДН нь эрх чөлөө, ардчиллын шинэ утга агуулгыг бий болгодог.
- Бид дахин “өшөө илүү ардчилалд зоригломоор” байна. Нийгмийн ардчилсан ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл нь Германы ардчиллын байдалд шүүмжлэлтэйгээр хандах болно. Үүндээ тэрээр амьдралын бүх хүрээний ардчилсан оролцооны шинэчлэлийн замыг эрж хайх болно.
- Эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэл, нийгмийн ардчиллын үндсэн үнэ цэнийг бий болгоход ардчилсан үндсэн хууль хэрэгтэй. Үүнгүйгээр тэднийг бий болгож болохгүй. Зөвхөн ийм нөхцөлд ард иргэд – хэрэв энэ боломжтой бол – дэглэм журам, дарангуйлал болон зааварчлалгүйгээр чөлөөтэй амьдрах болно. Тэдний эрх чөлөө нь бусад иргэдийн эрх чөлөөний өмнө хүлээсэн хариуцлагаар хязгаарлагдана. Ард иргэд эрх чөлөөгөө ардчиллын үед бие биентэйгээ харилцан эв нэгдэлтэйгээр хамгаалдаг.
- Хүмүүс ардчиллаас улс төрийн маргаан, шийдлүүдийн чөлөөтэй оролцоог найдаж болно. Энэ нь ард иргэдэд “Иргэн байх нь идэвхтэй байна гэсэн үг” гэсэн шаардлагыг тавьдаг. Эрх чөлөө нь түүнийг эзэмшихээс өмнө тодорхой чармайлтыг шаарддаг.
- Эрх чөлөөтэй хүмүүс нь ардчилсан шийдвэртэй хамтран шийдвэрлэхийн тулд материаллаг болон соёлын тодорхой шаардлагыг хангасан байх хэрэгтэй. Энэ ч бас эв нэгдэлтэй байх үүргүүдийн нэг. Ардчилсан нийгмүүд нь ард иргэд харилцан бие биэндээ тухайн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг олгодог дээр оршин тогтнодог. Энэ нь нийгмийн ардчиллын гол нөхцөл нь юм.
- Ардчиллын байгууллагууд ард иргэд нь маргалддаг, хамтран шийдэлцдэг байхаар зохион байгуулагдсан байх ёстой. Ардчилалд үйл ажиллагааны чадвартай төр хэрэгтэй. Хэн төрийг сулруулахав, тэр мөн ардчиллыг сулруулж байна гэсэн үг. Эцсийн эцэст



ардчиллын үеийн нийгэм, эдийн засаг нь эрх чөлөөтэй, идэвхтэй иргэд бий болох талбар байх хэрэгтэй. Ардчилал нь зөвхөн зохион байгуулалтын зарчим биш, харилцан хүндэтгэж, хувийн онцлогийг тэвчсэн амьдралын нэг хэлбэр юм.

Манай ардчиллын өнөөгийн байдал

Энэ хэмжүүрүүдтэй харьцуулахад манай ардчилал өв тэгш биш. Тэр ч байтугай Германд ардчилал хүчин чадлаа алдсаны олон шинж тэмдгүүд байна. Гэвч одоо бид намуудын ардчилал иргэдийн олон талт санаачлагуудтай давхацсан, бас түүгээр орлуулагдсанаас болж хямралд орж байгаа буюу эсвэл үнэхээр оролцоо боломжгүй болж байгаагийн алин болохыг мэдэх боломжгүй байна.

Харин ямар боловч хүмүүсээс асуусан асуулгаас үзэхэд одоо байгаа ардчилалд улам олон хүн итгэлгүй болж байгаа нь тодорхой. Эдийн засгийн хөгжлийн хурд болон ардчиллын шийдвэрүүдийн явц бие биенээсээ холдож байгаа нь харагдаж байна. Энэ нь ардчиллыг дарамтанд оруулж байгаа. Зах зээлийн радикалчид түүнийг орчин үеийн эдийн засагт хангалттайгаар үр ашигтай байж чадсангүй гэж буруутгаж байгаа юм. Түүнтэй зэрэгцэн дэлхийн эдийн засгийн хөгжлийн зохицуулалтын бодлого ардчилсан, хуульчилсан үндэсний бодлогыг хязгаарлаж байна.

Хямралын шинж тэмдгүүд хангалттай олон: Хувь хүний үйл ажиллагаа хаана олз ашгаа нэмэхэд чиглэсэн байна, тэнд ардчисан буянт үйл алга болдог. Эдийн засгийн хямралууд, нийгмийн ижил тэгш бус байдал, элит хэсгийн бусдаас тасрах тасралт, улам ихсэж буй доод давхаргыг гадуурхах гадуурхалт, түүнчлэн олон улсын хэмжээнд хоорондоо хэлхэлдсэн улс төрийн системийн шийдвэрийн иж бүрэн байдал зэрэг нь нийгэм дэх оролцоог улам бүр боломжгүй болгож байгаа сэтгэгдлийг төрүүлж байна.

Улс төр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон эдийн засгийн секторт боловсрол эзэмшсэн дунд түвшнийхэн дийлэнх хэсгийг эзэлдэг. Улс төрийн тавцан хувь хүмүүсийн санаа бодлын болон зугааны зах зээл болон хувирах аюулд тулгарлаа. Энэ нь бидний санааг зовоох ёстой. Зөвхөн бүх иргэд нь хариуцлагатай, улс төрийн амьдралд амжилттай оролцох боломжтой байж л амьд ардчилал оршин тогтнож чадна.

Ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл нь ардчиллыг гол сэдвээ болгон ажиллах болно. Бид биеэ даасан улс төржсөн иргэдийн оролцоотой маргалдааныг явуулах болно. Энд ажлын талбар дахь, үйдвэр дэх, олон нийт дахь, улс төрт нийтийн мөн чанар дахь амьд ардчиллын тухай яригдаж байна.

Энд сонирхол бүхий иргэдийг намын үйл ажиллагаанд оролцуулах, оролцооны шинэ арга ажиллагааны талаар яригдаж байна. Түүний хажуугаар бид ардчиллын болон иргэний хөдөлгөөнүүд, интернетийн идэвхтэнүүд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын дарга нар болон бусад чухал группүүдтэй харилцах харьцааны замыг эрж хайх болно. Бидний зорилго нь улс төрийг үзэн ядах ядалт, ардчиллаас хол хөндий байдал, гомдол бухимдлын талаарх маргаан зэргийн эсрэг амьд арчиллын төлөө тодорхой бодлого явуулах явдал билээ.

Ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төслийн гол асуудлууд

1. Ардчилсан оролцоо

Улс төрийн шийдвэрт оролцох оролцоо нь ардчиллын илэн далангүй байдал болон Rückhalt... ын хэм хэмжээ юм. Улс төрд оролцох оролцоо олон салбарт явагддаг: Парламентад, намууд болон хөдөлгөөнүүдэд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх нээлттэй маргаанд эсвэл өөр бусад иргэдийн санаачлагад г.м.

Оролцоо нь ямар нэг ёс төдий асуудал биш. Германд хэдийгээр ёс төдий ил тод байдал байдаг боловч оролцооны боломжуудыг хавчигдуулсан тухай олон мэдээ бий. Гэвч сүүлийн үед сонгуульд оролцох оролцоо байнга багасаж байгаа нь илт билээ. Үүнд олон шалтгаан бий. Маш бага тохиолдолд сэтгэл дундуур байдлаас болдог. Тиймээс ч ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл нь ёс төдий хамтран оролцох оролцоо ба иргэдийн нөлөөлөх нөлөөний бодит бололцооны хоорондох зөрчлийг авч үздэг.



Ихэнх иргэд ардчилсан оролцоог хавчигдмал зүйл гэж үздэг. Тэд сүүлийн жилүүдэд эдийн засгийн ашиг сонирхол хэт хүч давамгайл болсон мэт тул иргэдийн эрх тэгш байдалд үнэмшихээ больжээ. Тэдэнд гаргаж буй шийдвэрүүд яах аргагүй цаеэеəäçé áèàèççèýð ðòíé äýñýí ìýðäýèäýúíä захирагдах буюу илүү ашиг сонирхолд түрэгддэг гэсэн бодолтой болсон. Улс төрийн ажиллагаануудын иж бүрэн байдал нь иргэд өөрсдийн санал бодлоо илэрхийлэхэд саад болж байна.

Бидэнд дараах асуудлууд байна:

- Германд яагаад сонгуульд оролцох оролцоо багасаж байна вэ?
- Иргэний санаачлага намын ардчиллын дараа орох ардчиллын шинэ үлгэр жишээ юу?
- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн, баян ба ядуугийн, залуу хөгшний, зүүн ба баруун германы хүмүүсийн, өөр өөр боловсролтой хүмүүсийн хоорондох ялгаа ардчилсан оролцоонд ямар ач холбогдолтой вэ?
- Залуу сонгогчид, нийгмийн болон санхүүгийн талаас гадуурхагдагсад, гаднаас нүүж ирэгсэд, зүүн германыхан зэрэг сонгуульд оролцох оролцоо эрс багатай хүн амын хэсгийг ардчилсан оролцоонд яаж урамшуулан татах вэ?
- Иргэд манай нийгмийн хувь заяаг хамтран шийднэ гэдэгтэй итгэж байна уу?
- Эдийн засгийн логиктой зөрөлдөөнд ордог ардчиллын анхдагч шинж чанар гэж бий юу?
- Улс төрийн олон нийтлэг чанар бүтэж байна уу?
- Бидэнд шинэ плебисцит буюу интернетийн оролцоо мэтийн шинэ хэсэгчилсэн элементүүд хэрэгтэй юу?
- Ардчиллын хувийн, соёлын ба материаллаг урьдчилсан нөхцөл юу болж байна вэ?
- Улс төрийн боловсролын одоогийн санал хангалттай юу?

2. Нийгмийн ардчилал ба эдийн засаг

Нийгмийн ардчилсан ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл одоогийн хямралыг ардчиллын шалгуур гэж үздэг. Өнөөг хүртэл сонгогдож байсан ардчилсан засгууд олон улсын санхүүгийн зах зээлийг зохицуулж чадахгүй байгааг ард түмэн гайхан харж байна. Эдийн засгийн хямрал манай орны ардчиллын шалгуур болж болно. Ер нь зах зээлийн тодорхой дүрэм журам, санхүүгийн хямрал үүсгэгчдийг санхүүгийн талаар татан оролцуулах зэрэг арга хэмжээг бий болгож болох уу?

Сүүлийн хорин жилд эдийн засгийн хөгжил, ардчилал хоёр зөрөлдөөнтэй байдалд байгаа гэсэн ойлголт иргэдийн дунд бий болсон. Тэр ч байтугай олон либералчууд энэ байдал эсрэг тэсрэг буюу дор хаяж эрэмбэ дараатай байна гэж үздэг. Эхлээд дэлхий нийтийн өрсөлдөөн, дараа нь үндэсний ардчилсан шийдвэрүүд үүнд орно. Энэ логикоор ялангуяа хамтран шийдэх гэдгийг өрсөлдөөнийг саатуулагч хэмээн шүүмжлэн, улс төрийн шийдвэрийг улам ихээр хувьчлах болсон.

Ардчилал нь ийм логикийн үед зөвхөн эдийн засгийн зах зээлийн нэг бүтээгдэхүүн л болох юм. Тэрээр зах зээл болон нийгмийн үйл явцад шаардлагагүй болно. Олон эдийн засагчид Хятад, Орос мэтийн орнуудад оролцоог хатуугаар удирдан зохицуулдаг явдлыг үлгэр жишээ зүйл мэтээр үнэлдэг.

Бидний одоогийн туулан өнгөрүүлж буй эдийн засгийн хямрал бидэнд арай өөр зүйлийг сургаж байна. Жигд биш ажиллагаатай зах зээлүүд байнгын, хүчтэй, тасралтгүй өсөлтийг авчрахгүй. Тэд эдийн засгийн талаар давамгайл биш. Герман улс бусад олон орныг бодвол одоог хүртэл хямралыг сайн давж байгаад хамтран шийдэлт болон ажлын зах зээлийн журам зэрэг хүчин зүйлүүд хэцүү цагт ач тусаа өгч, зарим үед илүү хүнд байдалд орохоос ч хамгаалж байна. Энэ нь нийгмийн ардчилсан, эдийн засгийн ардчилалд чиглэсэн улс төрд ч тус дэм өгч байна.

Социал демократууд нийгмийн ижил тэгш байдал, ардчилсан оролцоог эдийн засгийг чөдөрлөгч гэж үздэггүй. Харин ч эсрэгээр, тэднийг нийгмийн эдийн засгийн зохицуулагч хүрээ ба зорилт гэж үздэг. Нийгмийн ижил тэгш байдал болон ардчилсан оролцоо нь хяналт шалгалтгүй гуйвуулж, хүний амьдралын бүх хүрээг үнэ цэнэгүй болгодог явдлаас эдийн засгийг хамгаалдаг. Тиймээс бид чөлөөтэй амьдрахын тулд олон нийтийн өмч, хүний амьдралын хүрээний аль хэсэг нь эдийн засгийн логикт захирагдахгүй байх вэ гэдгийн төлөө ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл ажилладаг.

Бидэнд дараах асуудлууд байна:



- Баян, ядуугийн ялгаанд ардчилал хэрхэн ханддаг вэ? Ижил тэгш бус байдал оролцоонд саад болох уу?
- Ардчиллын хувийн, соёлын болон материаллаг нөхцлүүдийг бид яаж хамгаалах вэ?
- Германы эдийн засгийн ардчиллын одоогийн хэрэгсэл хүчин төгөлдөр хэвээрээ юу?
- Даяарчлал буюу зах зээлийн европчлол ардчилалд ямар үр нөлөө авчирал вэ?
- Эдийн засгийн ардчиллын талаарх нийгмийн ардчилсан ойлголт даацтай хэвээр үү?
- Улс төрийн анхдагч шинж чанар гэж байдаг уу?
- Эдийн засгийн ардчиллын орчин үеийн хэлбэр ямар байж болох вэ?
- Байгалын нөөцөд хүрэхэд ардчилсан оролцоо байж болох уу, байх ёстой юу?

3. Гол асуудал бол эрх чөлөө ба шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь иргэний нэг чухал эрх. Түүгээр аливаа нэг нийгмийн эрх чөлөөний хязгаарыг хэмжиж болно. Чөлөөтэй санаа бодол зөвхөн төрөөс дарамтгүйгээр оршин тогтноно. Энэ нь хэдийгээр дэлхий нийтээр биелэгдэж чадахгүй байгаа боловч ердийн ойлгомжтой асуудал.

Чөлөөтэй санаа бодлыг зөвхөн дарангуйлан захирах засгаас ч заналхийлдэг бус. Чөлөөтэй санаа бодол тавтай тухтай зүйл биш л дээ. Эсэргүүцлийг бүх нийтээрээ ер нь таашаадаггүй. Иргэн бүхэн олон нийтийн амьдралын аягүй эвгүй зүйлтэй зууралдахыг хүсдэггүй. Эх адаггүй мэдээллийн эх сурвалж, харилцааны сувгууд эрх чөлөөнд шууд олз ашиг авчрахгүй нь лавтай.

Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдал үргэлж сонирхолтой байдаггүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид сонин хэвлэл, зурагтад элдэв шуугиан тарьсан зүйл мэдээлнэ гэвэл түүнийгээ мэдээний оронд гаргадаг туршлага бий. Хэрэв олон нийтийн чухал сэдвүүд түр зуурын, сонирхол татсан олон зүйлсийн дундаас сугаран нэвтэрч чадахгүй бол санаа бодлын эрх чөлөө утга санаагаа алдана.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд энд бас тодорхой хариуцлага хүлээх ёстой. Хүмүүс зөвхөн зүг чигээ олж чаддаг байж л жинхэнэ эрх чөлөөтэй болно. Үүнийг мэдээллийн олон талт байдал бий болгодог. Энэ нь зөвхөн улсын албан ёсных ч биш, мөн хувийн болон интернет дахь хэвлэл мэдээллийн байгууллагууд юм. Сонин болон хувийн зурагт радиогийн төвлөрөл нь ардчилсан яриа хөөрөөнд аюул учруулж байна. Энэ асуудал хэдийгээр харилцааны мэргэжил сурч эзэмшсэн боловч, мэдлэг султай, улс төрийн үндсэн үнэмшил улам багатай болж байгаа шинэ залуу сэтгүүлчдийн үед ч бас хамаарна.

Шинэ маягийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлэл харилцааны хязгааргүй эрх чөлөөг буй болгож байна. Юуны өмнө интернетийн хөгжил нь оролцооны болон мэдээллийн шинэ шинэ боломжуудыг нээж байна. Тэд бүгдэд хүртэх, тус болох эсэх нь ерөнхий нөхцлүүдийг яаж зохицуулснаас хамаарна.

Дэлхий даяарх мэдээлэл болон өө өй мэдээ, өй аа өө өй эдийн засгийн хувийн сектор монополичлох явдал эрх чөлөө, ардчилалд шинэ аюул авчирч байгаад улс төр хариу олох ёстой. Шалган мөрддөг төр гэдгийн дараа хөдөлгөөний профиль, хэрэглэгчийг таних арга эсвэл бусад аргууд зэрэг шинэ техникийн боломжууд бий болсон.

Тиймээс ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл доорх асуултуудыг тавьж байна:

- Манай нийгэм яаж шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслийн боломжийг ашиглаж, олон нийтийг хуваагдмал болох эрсдлээс сэргийлж чадах вэ?
- Web 2.0 нь улс төрийн сэтгэлгээ, үйл ажиллагааг яаж өөрчлөх вэ?
- Оролцооны боломжуудад интернетийг яаж ашиглах вэ?
- Интернетэд яаж буурь суурьтай, бодит маргаануудыг явуулж болох вэ?
- Хэвлэл мэдээллийг төвлөрөл, монополичлол, хэрэглэгчийн логик, ганцаардал, шунан тачаадах өвчтэй болох, байнгын хяналт зэрэг үл бүтэх зүйлээс хамгаалах вэ?
- Тэрээр сүлжээн дахь зохиогчийн эрхтэй яаж харьцах вэ?
- Дэлхийн дигиталчлал цахимжуулалт ямар хагарлуудыг үүсгэж байна вэ?
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бид ардчилал хэвшүүлэхэд түүний оруулах хувь нэмрийн талаар ярилцлагад урьж чадах уу?



4. Улс төрийн үйл ажиллагаанд тохиолдох саад тотгорууд

Үндсэн хуулийн 21 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт намуудын үүрэг ролийг “Намууд ард түмний улс төрийн хүсэл зоригийг бий болгоход оролцоно. Тэдний дотоод зохион байгуулалт ардчилсан зарчмын дагуу байх ёстой. Тэд өөрсдийн мөнгөний эх үүсвэр, зарцуулалт болон хөрөнгөнийхөө талаар нийтэд тайлагнах ёстой.” гэж тодорхой заасан. Зорилго нь намууд, үүгээрээ нэг бодлого болон хүчирхэг хэсгийн ашиг сонирхолд биш, иргэдийн хүсэл зоригт үйлчлэх явдал юм. Олон хүмүүс намын дотоод үйл ажиллагааны ил тод байдалд эргэлздэг

Тиймээс ирээдүйн ажил болох “Ардчилал ба эрх чөлөө” төсөл доорх асуултуудыг тавьж байна:

- Намууд хир зэрэг илэн далангүй вэ?
- Намууд ард түмний дуу хоолой болж, улс төрийн хүсэл зориг бий болоход тоглогч нь болж чадаж байна уу?
- Намууд улс төрийн удирдлагыг бүрдүүлэхэд өөрийн үүргээ гүйцэтгэж чадаж байна уу?
- ГСДН өөрийгөө хир зэрэг ардчилсан гэж үздэг ба бусад нь түүнийг юу гэж үздэг вэ?
- ГСДН өөрийгөө тусгаарлах болон бусад намуудын адил хэл болон хэв заншлаараа бусдаасаа ялгардаг уу?
- ГСДН-ын дотоод ардчилал ямархуу байна?
- ГСДН-ын нээлтэй байдал хир зэрэг вэ?
- Социал демократууд өөрийн шаардлагадаа яаж нухацтай ханддаг вэ?
- Лоббидолт болон ашиг сонирхлын группүүдийн нөлөөг яаж хязгаарлах вэ?

* ГСДН – Германы социал демократ нам – орч.